

Монгол хөөмийн урын сангийн баримтжуулалт: МҮОНР-ийн хөгжмийн архив

Мөнхжаргалын Амаржаргал 

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
✉ amarjargal.m@mnuac.edu.mn

Хураангуй: Монгол хөөмий нь ардын язгуур урлагийн хосгүй өв бөгөөд өнөөг хүртэл аман уламжлалаар дамжин хөгжиж ирсэн онцлогтой. Энэхүү судалгааны зорилго нь Монголын Үндэсний Олон Нийтийн Радио (МҮОНР)-ийн хөгжмийн фонд дахь хөөмийн баримтжуулалтад ажиглалт судалгаа хийж, тэдгээрийг нэгтгэн мэдээлж, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулахад чиглэгдэнэ. Судалгааны явцад МҮОНР-ийн эргэлтийн сан хөмрөг дахь 3000 гаруй монгол ардын богино болон уртын дууны бичлэгийн сангаас хөөмийн холбогдолтой бичлэгүүдийг шүүж, он дараалал, агуулга, уран бүтээлчийн гүйцэтгэл, хөгжмийн зэмсгийн хамсраа зэрэг үзүүлэлтээр ангилан шинжилсэн. Түүнчлэн радиогийн хөгжим-уран сайхны нэвтрүүлгүүдээс хөөмийн тухай контентыг мөн шүүж мэдээлсэн. Энэ нь хөөмийн урын сангийн хөгжлийн зүй тогтлыг илүү нарийвчлан судлах, өвлүүлэн түгээхэд ач холбогдолтой юм.

Энэхүү судалгаа нь МҮОНР-ийн архивд хадгалагдаж буй хөөмийн урын сангийн үнэ цэнийг тодорхойлж, системтэй баримтжуулах, шинжлэх ухаан, судалгааны эргэлтэд оруулахад чухал хувь нэмэр оруулах төдийгүй хөөмийн уран бүтээлийн уламжлалт болон орчин цагийн шинэчлэгдсэн хэлбэрүүдийн харьцуулалт судалгаа хийх суурь мэдээллийг бүрдүүлэхэд чиглэгдэж байна.

Түлхүүр үгс: *хөөмийн уламжлалт урын сан, радио архив, дижитал хадгалалт, угсаатны хөгжим судлал*

Documentation of the Mongolian *khöömii* repertoire: The music archives of the Mongolian Radio

Amarjargal Munkhjargal 

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
✉ amarjargal.m@mnuac.edu.mn

Abstract: Mongolian *khöömii* is a unique intangible cultural heritage that has been transmitted and developed through oral tradition for centuries. This study aims to document, classify, and introduce the archival collection of *khöömii* recordings

preserved in the Musical Archives of the Mongolian National Public Radio (MNB Radio) into scholarly discourse. During the research process, *khöömii*-related recordings were identified and analyzed from a collection of over 3,000 Mongolian folk songs, including both long-song (urtyn duu) and short-song (bogino duu) recordings preserved in the MNB Radio archives. These recordings were classified based on chronology, thematic content, artistic performance, and instrumental accompaniment. Additionally, *khöömii*-focused content within the radio's music and arts programs was cataloged and documented, contributing to a deeper understanding of the systematic evolution of the *khöömii* repertoire and its transmission.

This study provides a structured documentation of the *khöömii* repertoire within the MNB Radio archives, highlighting its cultural significance and making it accessible for further academic and artistic research. Moreover, it serves as a fundamental resource for comparative studies on traditional and contemporary innovations in *khöömii* performance and composition.

Keywords: *traditional khöömii repertoire, radio archives, digital preservation, ethnomusicology.*

Оршил

Монгол ардын язгуур урлагийн онцгой төрөл болох хөөмий нь олон зууны турш аман уламжлалын хэлбэрээр дамжин өнөөдрийг хүртэл өвлөгдөн ирсэн. Анх “Алтайн магтаал”-ын дунд хөөмийн ая аялгууг оруулан найруулж тайзнаа эгшиглүүлсэн Д.Лувсаншаравын санал, санаачилга эдүгээ “хөөмий” гэх хосгүй өвийг тайзны урлаг болж хөгжих үндэс суурийг тавьсан. Түүнээс хойш ардын болон уртын дууг хөөмийчид өөр өөрсдийн арга барилаар хөөмийлөх, цаашлаад ардын дууны найруулга, түүнээс сэдэвлэсэн том, жижиг хэлбэрийн бүтээл туурвих оролдлого, хандлагууд түгээмэлжиж, салбарын урын сан баяжсаар байна.

Урын сан нь уг урлагийн өвөрмөц хөг аялгуу, гүйцэтгэлийн хөгжил, хувьслыг илэрхийлэхээс гадна, язгуур хөгжмийн уламжлалыг тодруулахад анхааран судлах шаардлагатай нэг чиглэл мөн. Ялангуяа орчин цагийн хөгжмийн урлагт мэргэжлийн түвшинд тодорхой байр суурийг эзлэн хөгжиж буй эл урлагийн уламжлалт урын санг тодруулан судлахад аман түүхийн судалгаа хийгээд дуу, дүрсний бичлэг, хувь хүн албан байгууллагын сан хөмрөгийг мөшгөн судлах нь зайлшгүй юм. Гэвч хөөмийн урын санг онцлон судалж, баримтжуулах ажил харьцангуй хожуу эхэлсэн учраас, өнөөг хүртэл архивын системтэй судалгаа хангалтгүй байна. Монголын Үндэсний Олон Нийтийн Радио (МҮОНР)-ийн хөгжмийн архивт хөөмийн урын санд хамаарах дуу бичлэгийн үнэт эх сурвалж хадгалагдаж байгаа тул тэдгээрийг судлан тодруулах, ангилан төрөлжүүлэх, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах шаардлагууд бидний өмнө тулгарч байна. Тиймээс бид энэ удаад хөөмийн урын сангийн дуу бичлэгийн баримтжуулалтын асуудлыг МҮОНР-ийн хөгжмийн архиваар жишээлэн авч үзэж, баримт, эх сурвалжтай мэдээлэх зорилгыг эрхэмлэв.

Судалгааны арга зүй

Судалгааны өгөгдөл, эх сурвалжийг МҮОНР-ийн хөгжмийн фондын хадгаламжийн нэгжүүд буюу хальс болон бичлэгийн архивд тулгуурлан

цуглуулсан бөгөөд ажиглалт, харьцуулалт, баримт бичгийн судалгаа, системчлэн бүртгэлжүүлэх аргуудыг хослуулан дараах байдлаар гүйцэтгэв.

1. Баримт бичгийн судалгаа (Documentary Research):

- МҮОНР-ийн хөгжмийн сан хөмрөг дэх 3000 гаруй ардын дууны хальс бичлэгийг шүүж, хөөмийн холбогдолтой нэгжүүдийг тодорхойлов.
- Францын угсаатны хөгжим судлаач, доктор Жонни Кюртэгийн (Johanni Curtet 2013, 456-459) судалгаанд дурдагдсан бүтээлүүдтэй харьцуулалт хийж, хөөмийн урын сангийн олон улсад судлагдсан байдлыг нягтлав.

2. Харьцуулалт, ангиллын судалгаа (Comparative and Classification Analysis):

- Бичлэгүүдийг он дараалал, агуулга, уран бүтээлчийн гүйцэтгэлийн онцлог, хөгжмийн хамсрааны бүрэлдэхүүн зэргээр ангилан шинжлэв.
- Хөөмийн уламжлалт болон орчин үеийн илэрхийллүүдийг ялган, хөгжмийн бүтцийн онцлогийг тодруулав.

3. Системчлэн бүртгэх, архивын судалгаа (Archival Documentation & Systematization):

- Хөөмийн бичлэгийн нэгдсэн бүртгэлийг МҮОНР-ийн хадгаламжийн нэгж (данс)-ийн дугаар, гүйцэтгэгч уран бүтээлчийн нэр, бичлэг хийгдсэн огноо, үргэлжлэх хугацаа, хөгжмийн хамсрааны бүрэлдэхүүн зэрэг мэдээллээр бүрдүүлэв.
- Зарим хальс, хадгаламжийн нэгж дээр хөгжмийн хамсрааны талаарх тэмдэглэгээ дутмаг байсан тул медиа архивд суурилж анализ хийв.

4. Шууд ажиглалт, баталгаажуулалт (Direct Observation & Verification):

- Судалгааны үнэн зөв байдлыг нэмэгдүүлэх зорилгоор МҮОНР-ийн Уран зохиол, соёл урлагийн албаны уран бүтээлчидтэй хамтран хөгжмийн найруулга, хамсрааны талаарх мэдээллийг баталгаажуулсан.
- Мэдээллийн зөрүүтэй хэсгүүдэд дахин сонсгол хийж, хөөмийчдийн урын сангийн онцлогийг тодотгов.

Судалгааны үр дүн

Радиогийн эфирийн өдөр тутмын нэвтрүүлгийн эргэлтэд байдаг дуу бичлэгүүд үндсэндээ ардын дуу (уртын, богино), гадаад дуу, зохиолын дуу, хөгжим-уран сайхны нэвтрүүлэг, хөдөө орон нутгийн шууд бичлэгийн хальс (трансляц) зэргээс бүрдэх бөгөөд эргэлтийн сан хөмрөгт нийт 50000 (тавин мянга) гаруй хоёрдогч хувь бүхий хальс хадгалагдаж байна. Харин дуу хөгжмийн бичлэгүүдийн эх хувь болон ховор, нандин бичлэгүүдийг “Алтан фонд”-д хадгалж байна. Бид судалгааны явцад эргэлтийн сан хөмрөгөөс зөвхөн хөгжим-уран сайхны нэвтрүүлэг, ардын дууны бичлэгийг голчлон шүүж үзэх боломж олдов. Харин гадаад болон зохиолын дууны олон мянган бичлэгийн жагсаалт тодорхойгүй, хальс тус бүрийг нэг бүрчлэн үзэх, сонсох шаардлага тулгарсан тул судалгаанд зарцуулах цаг хугацаанаас хамаарч энэ удаагийн илтгэлд бүрэн мэдээлэх боломжгүй байв. Иймээс бид хөгжим-уран сайхны нэвтрүүлгийн 106 хальсны бүртгэл, “Ардын дуу”-ны 3270 хальсны I, II ботийн бүртгэл, жагсаалтыг тулгаж, мэдээллийн үнэн зөвийг нягталж, дансны дугаараар хадгаламжийн нэгжүүдийг санамсаргүй түүврийн аргаар тулгаж үзэв.

“Ардын дуу” I, II боть бүхий жагсаалтад 1962-2000 онд хамаарах Г.Чимэддорж (Ховд), Д.Сундуй (Ховд), н.Замзай (Баян-Өлгий), н.Рысбек (Баян-Өлгий), н.Пүрэвдорж (Завхан), Н.Сэнгэдорж (Ховд), С.Хас-Очир, Д.Цэрэндаваа (Ховд), Р.Даваажав (Ховд), н.Пүрэвээ (Баянхонгор), н.Мөнхсанаа (Увс), С.Минжээсүрэн (Ховд), Т.Ганболд (Ховд), Ш.Даш (Хөвсгөл), Э.Сандагжав (ТЗДБЧ), А.Бат-Очир (УАДБЧ), Г.Алимаа (УАДБЧ), Ц.Цэрэндорж (Завхан), Д.Гантулга (“Түмэн эх” чуулга), Б.Бат-Орших (“Домог” хамтлаг), Б.Амартүвшин (“Домог” хамтлаг), Д.Хосбаяр (“Эгшиглэн” хамтлаг), Б.Батжаргал (“Түмэн эх” чуулга), Я.Цогбаатар (“Мандухай” чуулга) нарын 23 уран сайханч, уран бүтээлчийн гоцлон хөөмийлсөн 58 хальсанд 97 дуу, бүтээл; хамтлаг болон хоршиж хөөмийлсөн 15 хальсанд 17 бүтээл, нийтдээ 73 хальсанд давхардсан тоогоор 114 ардын дуу, магтаал, зохиомжит бүтээлүүд бичигджээ. Нэг хальсанд 1-2 дуу бичигдсэн нь түгээмэл бол цөөн уран сайханчдын бичлэгт 3-5 дууг нэг хальсанд бичүүлсэн байна. Мөн нэг хүн нэг дууг өөр цаг үед давтаж бичүүлсэн, “Гоож Нанаа”, “Цомбон туурайтай хүрэн” гэх зэрэг дуунуудыг хэд хэдэн уран бүтээлчид өөр өөрсдийн хэв намбаар хөөмийлж бичүүлсэн байгаа нь судалгааны явцад ажиглагдав.

1950-аад оны дунд үеэс хөөмийг тайзнаа анхлан эгшиглүүлсэн Ховд аймгийн С.Цэдээгээс Улсын хөгжимт драмын театр (тухайн үеийн нэршлээр УХДТ)-т ноот бичигч, найрал дуучнаар ажиллаж байсан Г.Чимэддорж хөөмий сурч, ардын болон уртын дуунуудыг аялгуулан хөөмийлөх болсон (Сандагжав 2009, 40) талаар судлаачид ном бүтээлдээ тэмдэглэсэн байдаг. Тэгвэл хөөмий болон хулсан хуурт хэрхэн суралцаж, дэлхий дахинд нэрээ дуурьсгаж, уралдаан наадамд оролцож явсан түүний ур чадварыг мөнхөлсөн хэд хэдэн бичлэгүүд радиогийн фондод хадгалагдан үлджээ. Дэлхийн залуучууд, оюутны VI их наадмын шагналт хөөмийч Г.Чимэддорж УХДТ-т ажиллаж байхдаа радиогийн фондод 11 дуу бичүүлсэн нь эдүгээ эргэлтийн сан хөмрөгт дараах данс, дугаарт хадгалагдаж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Хөөмийч Г.Чимэддоржийн радиогийн фонд дахь дуу бичлэгүүд

Д.д	Хөөмийлсөн бүтээл	ХН дугаар	Огноо	Хугацаа	Нэмэлт мэдээлэл
1	“Цомбон туурайтай хүрэн”	№3664	1962.01.06	00:04:00	Ёочинч Ц.Дашдаваа
	“Гунан хар”				
	“Шаргын шаргын жороо”				
2	“Гунан хар”	№3511	1962.06.01	00:01:26	Хөгжимдүүрийн хамсраагүй, исгэрээ хөөмий
3	“Говийн өндөр”	№3510	1962.06.01	00:02:20	
4	Буриад ардын дуу: “Хүдэр дунгуйдаа нутагтай”	№3496	1962.06.03	00:02:00	
5	“Цомбон туурайтай хүрэн”	№31359	1962.06.05	00:04:31	Ёочингийн хамсраатай (Ц.Дашдаваа)
	“Гунан хар”				
	“Дөрвөн настай халиун”				

6	“Буурал морь”	№3509	1962.06.08	00:01:38	Хөгжимдүүрийн хамсраагүй, исгэрээ хөөмий
7	“Мандах нар”	№3501	1962.06.10	00:01:05	
8	“Хонин жороо морь”	№3508	1962.06.15	00:00:54	
9	Баруун монгол ардын дуу: “Алтай хааны магтаал”	№3497	1962.06.28	00:01:25	
10	“Дөрвөн настай халиун”	№3499	1962.06.28	00:02:26	

Дээрх хүснэгтийн мэдээллээс харахад “Цомбон туурайтай хүрэн” дууг 1962 онд 2 удаа, “Тунан хар” дууг мөн онд 3 удаа давтан бичүүлсэн байна. Ингэхдээ хоёр удаагийн дуу бичлэгт ёочин хөгжмийн хамсрааг ашигласан ба бусад дуунуудыг хөгжмийн хамсраагүй исгэрээ хөөмийгөөр хөөмийлжээ.

Харин Монгол Улсын Гавьяат жүжигчин, нэрт **хөөмийч Д.Сундуйн** Ховд аймгийн Хөгжимт драмын театрт ажиллаж байхдаа буюу 1962-1969 оны хооронд радиод бичүүлж байсан 10 дууг олж тэмдэглээд байна. Эдгээрийг дараах хүснэгтээр үзүүлэв (Хүснэгт 2).

Хүснэгт 2. МУГЖ, хөөмийч Д.Сундуйн радиогийн фонд дахь дуу бичлэгүүд

Д.д	Хөөмийлсөн бүтээл	ХН дугаар	Огноо	Хугацаа /минут/	Нэмэлт мэдээлэл
1	“Говийн өндөр”	№31254	1962.05.11	00:01:01	Хөгжимдүүрийн хамсраагүй, исгэрээ хөөмий
2	“Эхийн ач”	№31257	1962.11.29	00:01:25	
3	“Тоож Нанаа” ¹	№31660	1962.10.25	00:00:56	
4	“Шидэн хуар”	№31778	1963.10.01	00:01:06	Морин хуурын хамсраатай (М.Довчин)
5	“Дөрвөн настай халиун” “Тоож Нанаа”	№31904	1965.07.18	00:02:55	Ёочингийн хамсраатай (Ж.Мэнд-Амар)
6	“Цомбон туурайтай хүрэн”	№31349	1969.05.22	00:01:50	Морин хуурын хамсраатай (И.Цогбадрах)
7	“Тоорой банди”	№31406		00:01:40	
8	“Хүрэн толгойн сүүдэр”	№31063		00:02:02	
9	“Эрүү цагаан болжмор”	№3544		00:01:27	

Хөөмийч Д.Сундуйн бичлэгүүдэд “Тоож Нанаа” дуу нэг удаа дангаар бичүүлж, нэг удаа “Дөрвөн настай халиун” дуутай хамт бичүүлсэн байгаагаас өөр дахин давтагдсан бичлэг байхгүй байна.

Францын угсаатны хөгжим судлаач Жоани Кюртэгийн судалгаанд Д.Сундуйн 1969 онд соронзон хальсанд (№31904, 1’03 минут) бичигдсэн “Говийн өндөр” дууг ашигласан талаар дурдсан (Johanni Curtet 2013, 457). Гэвч бидний судалгааны явцад эл бичлэгийн мэдээлэл олдоогүй. Магадгүй энэ нь “Алтан фонд”-д хадгалагдаж байх талтай. Мөн түүний судалгаанд радиогийн фондод байгаа хөөмийн бичлэгийн

¹ Тоож Нанаа: Радиогийн фондод “Тоож Нан ай” хэмээн тэмдэглэгдсэн. “Уг дуу нь Засагт хан аймгийн Эрдэнэ Дүүрэгч засгийн хошууны засаг ноён Намхайжанцангийн түүхэнд холбогдох дуу. Эрдэнэ Дүүрэгч засгийн хошуу нь одоогийн Завхан аймгийн Баянхайрхан, Баянтэс, Тэс, Асгат, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан-Уул сумын нутаг юм. Гомбо, Жигээ, Намхайжанцан, Дашбалжир гэх энэ дуунд холбоотой дөрвөн хүний нэрийн эхний үсгүүдээр “То Жи Нанаа Да” хэмээн нэрлэж байсан...” тухай сошиал мэдээ бий. (Fb: Банзрагчийн Түвшин, 2024.04.21).

анхны бичлэг 1957 онд Г.Чимэддорж, Д.Сундуй нарынх гэж дурдсан боловч бидний судалгааны хүрээнд олдсон мэдээллээр хамгийн анхны бичлэгийн он цаг 1962 оноос эхлэлтэй байна. Гэвч медиа архиваас сонсож үзэхэд эфирийн шаардлага хангахгүй гэсэн тайлбартай бичлэгүүд нэлээд байгаагаас үзвэл 1957 оны бичлэг устсан байх ч талтай.

Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, **хөөмийч Д.Цэрэндаваа** радиогийн фондод 1983, 1986, 1987, 1991 онуудад 6 удаагийн бичлэгт орохдоо гоцлол болон хоршил, хамтлаг хэлбэрээр 19 бүтээл бичүүлснээс 15 бүтээлийг гоцолж (Хүснэгт 3), 2 бүтээл Ш.Даштай хамтарч, 2 бүтээл “Жаргалантын цуурай” хамтлагийн бүрэлдэхүүнтэй хөөмийлжээ. Эдгээр бүтээлд “Алтайн магтаал”-аас бусад бүтээлд давхцал байхгүй, “Алтайн магтаал”-ыг 1983 онд ганцаар бичүүлж байсан бол 1987 онд хөөмийч Ш.Даштай хоршиж бичүүлж байсныг дараах хүснэгтийн нэгтгэлээс харж болно.

Хүснэгт 3. МУСГЗ, хөөмийч Д.Цэрэндаваагийн радиогийн фонд дахь дуу бичлэгүүд

Д.д	Хөөмийлсөн бүтээл	Хальсны дугаар	Огноо	Хугацаа /минут/	Нэмэлт мэдээлэл
1	“Алтайн магтаал”	№32275	1983.01.23	00:06:12	Магтаал, хөөмий (товшуур)
2	“Алтай хайлах тууль” магтаал	№32276	1983.01.21	00:06:08	Товшуурын хамсраатай
3	“Монгол гэрийн магтаал”	№32291	1983.01.24	00:02:40	
4	“Тоорой банди”	№32290-1	1983.01.24	00:01:34	Хөгжимдүүрийн хамсраагүй, исгэрээ хөөмийн гоцлол
	“Сэрэвгэр хадны зэрэглээ”	№32290-2		00:01:37	
	“Баянхайрхан”	№32290-3		00:01:31	
	“Сийлэн бөөр”	№32290-4		00:01:42	
	“Арван тавны сар”	№32290-5		00:01:42	
5	“Өнчин цагаан ботго” “Талын таван толгой”	№33132	1991.05.25	00:06:35	Морин хуурын хамсраатай (Морин хуурч И.Цогбадрах)
6	“Эрдэнэ уул” “Өөрийн нутаг”	№33133	1991.05.25	00:05:42	
7	“Дөрвөн настай халиун” “Гоож Нанаа” “Хүмүүн төрөлхтөн”	№32888	1987.12.07	00:05:15	Хуучрын хамсраатай (Хуучирч О.Болдоо)

Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, **хөөмийч Т.Ганболд** УАДБЧ-т ажиллах хугацаандаа буюу 1985, 1987 онуудад 7 ардын дуу, 1 зохиомжит бүтээлийг гоцлон хөөмийлж, 1987 онд дуучин Д.Түвшинжаргал, А.Нэргүй нартай хоршиж 2 бүтээл тус тус бичүүлжээ. Хожим нь 2005 онд хүү Г.Балжиннямтайгаа хамтран бүтээсэн “Тайхамшигт монгол хөөмий” цомгийн бичлэгээс 2 бүтээлийг 2014 онд, Говь-Алтай аймгийн үндэсний дуу бүжгийн “Алтай” чуулгын “Аялгуут сайхан Алтай нутаг” цомгоос 1 бүтээлийг тус тус радиогийн фондод хуулж авчээ. Түүний зохиож найруулсан “Монгол хөөмийн холбоо аялгуу” бүтээл нь морин хуурын хамсраатай ганцаар болон хоршиж хөөмийлсөн хоёр хэлбэрээр хадгалагдаж байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. МУСТА, хөөмийч Т.Ганболдын радиогийн фонд дахь дуу бичлэгүүд

Д.д	Хөөмийлсөн бүтээл	Хальсны дугаар	Огноо	Хугацаа /минут/	Нэмэлт мэдээлэл
1	“Алаг морь”	№32602	1985.05.29	00:02:47	Ёочин, ятгын хамсраатай (ёочинч Б.Алтантуул, ятгачин Г.Гантуяа) - хадгаламжийн дугаар зөрсөн
	“Буурал морь”				
2	“Сүндэр уул”	№32773	1987.06.23	00:05:30	Морин хуурын хамсраатай (морин хуурч И.Цогбадрах)
3	“Юндэн гөөгөө”	№32884	1987.09.11,	00:07:07	Ятгын хамсраатай (ятгачин Цэрэнхорлоо, Б.Алтантуул)
	“Сийлэн бөөр”				
	“Намрын хонгор салхи”				
	“Өөрийн нутаг”				
4	“Монгол хөөмийн холбоо аялгуу”	425 CD 10-р дуу	2012.06.14-нд медиа архивд	00:04:21	Морин хуурын хамсраатай (Ардын ДБ-ийн Алтай чуулгын “Аялгуут сайхан Алтай нутаг минь” цомог)

Монгол Улсын Гавьяат жүжигчин, **хөөмийч Р.Даваажав** худалдааны байгууллагын уран сайханч байхдаа 1982, 1983 онуудад нийт 7 дуу бичүүлжээ. Тэдгээрийг дараах хүснэгтээс харж болно (Хүснэгт 5).

Хүснэгт 5. МУГЖ, хөөмийч Р.Даваажавын радиогийн фонд дахь дуу бичлэгүүд

Д.д	Хөөмийлсөн бүтээл	Хальсны дугаар	Огноо	Хугацаа /минут/	Нэмэлт мэдээлэл
1	“Дөрвөн настай халиун”	№32206	1982.01.18	00:01:26	Хөгжимдүүрийн хамсраагүй, исгэрээ хөөмий
	“Тоож Нанаа”				
2	“Цомбон туурайтай хүрэн”	№32297	1983.01.24	00:01:10	
3	“Сийлэн бөөр”	№32436	1983.12.19	00:04:39	
	“Дөрвөн настай халиун”				
	“Хүрэн хаалгатай дэлгүүр”				
	“Тоорой банди”				

УАДБЧ-ын дуучин **Г.Алимаа** 1998, 2000 онуудад морин хуурын хамсраа болон ардын хөгжмийн цөөхүүлтэй нийт 7 дуу хөөмийлж бичүүлсэн байгааг дараах жагсаалтаас харж болно (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Хөөмийч Г.Алимаагийн радиогийн фонд дахь дуу бичлэгүүд

Д.д	Хөөмийлсөн бүтээл	Хальсны дугаар	Огноо	Хугацаа /минут/	Нэмэлт мэдээлэл
1	“Монгол хөөмий дөрвөн холбоо”	№33245	1998.01.20	00:03:32	Морин хуурын хамсраатай (Хуурч Д.Ариунболд)

2	“Дөрвөн настай халиун”	№33256	2000.10.10	00:02:49	Ардын хөгжмийн цөөхүүлтэй
	“Авгын цагаан уул”			00:01:45	
	“Тоож Нанаа”			00:00:56	
	“Буянт гол”			00:01:48	
	“Хонин жороо морь”			00:00:48	
	“Дөрвөн уул”			00:01:52	

Монгол Улсын Гавьяат жүжигчин, **хөөмийч Н.Сэнгэдорж** 1979 онд 3 дуу бичүүлж байсныг судалгааны явцаас тэмдэглэв. Энэ мэт радиогийн фондод 1-5 бүтээл бичүүлж үлдээсэн бусад уран сайханч, хөөмийчдийн дуу бичлэгийн жагсаалтыг он дарааллын дагуу нэгтгэн мэдээлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 7. Бусад хөөмийчдийн гоцлон хөөмийлсөн бичлэгийн жагсаалт

Д.д	Хөөмийчийн нэр	Хөөмийлсөн бүтээл	Хальсны дугаар	Огноо	Хугацаа	Нэмэлт мэдээлэл
1	н.Замзай ² (Баян-Өлгий аймгийн уран сайханч)	“Алтайн магтаал”	№31162	1967.07.11	00:02:45	Домборын хамсраатай
2		“Хос хүрэн”	№3675	1967.07.11	00:01:16	
3	Рысбек (Баян-Өлгий аймгийн уран сайханч)	Казах ардын дуу “Жанай Эрка”	№3326	1971.06.30	00:01:27	Домборын хамсраатай
4		Монгол ардын дуу “Ямар л амраг вэ”	№3839		00:01:15	
5	н.Пүрэвдорж (Завхан аймгийн уран сайханч)	“Тоож Нанаа, Гунан хар”	№3287	1971.07.03	00:01:23	Гитар хөгжмийн хамсраатай
6	Н.Сэнгэдорж (Ховд аймгийн уран сайханч)	“Тоож Нанаа”	№03723	1979.12.21	00:01:38	Ёочингийн хамсраатай (Архангай аймгийн ёочинч н.Энх-Амгалан)
7		“Буянт гол”				
		“Дөрвөн настай халиун”	№31602	1979.12.07	00:00:51	
8	С.Хас-Очир	“Дөрвөн цагийн тал” (Л.Мөрдорж)	№04054	1983.01.19	00:01:13	Хөгжимдүүрийн хамсраагүй, Исгэрээ хөөмий
9	н.Пүрэвээ (Баянхонгор аймгийн уран сайханч) Бүх ард түмний	“Ээвэн голын урсгал”	№32300	1983.01.20	00:01:55	Медиа архивд ороогүй
10		“Гарын арван хуруу”				
		“Говийн өндөр”	№32302	1983.01.20	00:00:56	
11	ЯУУҮ-ийн алтан медальт	“Дөрвөн настай халиун”	№32516	1984.10.02	00:02:37	Ардын хөгжмийн цөөхүүлтэй
		“Хонин жороо морь”				

² МУГЖ, Д.Жаргалсайхан 2024 онд өөрийн цахим хуудастаа 1963 онд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Монголын Залуучууд Оюутны II их наадам”-ын хөтөлбөрийг мэдээлсэн ба түүнд “...Алс баруун хязгаарын аялгууг төлөөлж “Залуучуудын алдар” нэртэй зохиолыг Баян-Өлгий аймгийн Булган сумын адуучин эр Замзаа домбор хөгжмөөр тоглож, хөөмийлсэн...” (Жаргалсайхан 2024) хэмээжээ.

12	н.Мөнхсанаа (Увс аймгийн уран сайханч)	“Цэнхэрлэн харагдах уул”	№32309	1983.01.20	00:04:20	<i>Медиа архивд ороогүй</i>
		“Тооройн цагаан элс”				
		“Миний хонгор хотод бий”				
		“Буурал морь”				
13	С.Минжээсүрэн (Ховд аймгийн уран сайханч)	“Дөрвөн уул”	№32437-1	1983.12.20	00:00:39	Хөгжимдүүрийн хамсраагүй, Исгэрээ хөөмий
		“Хонин жороо морь”	№32437-2		00:00:42	
		“Гунан хар”	№32437-3		00:00:42	
		“Тоож Нанаа”	№32437-4		00:00:34	
14	н.Дашдаваа (Хөвсгөл аймгийн уран сайханч)	“Хадат тоом”	№32687	1986.12.31	00:02:45	<i>Медиа архивд ороогүй</i>
		“Арван тавны сар”				
		“Дунд тоом”				
15	Ц.Цэрэндорж (Завхан аймгийн уран сайханч)	“Ээвэн голын урсгал”	№32958	1988.06.25	00:02:05	Хөгжимдүүргүй, Хархираа хөөмий
16	Э.Сандагжав (Завхан аймгийн ХДТ-ын жүжигчин)	“Дөрвөн настай халиун”	№ГА-40-5	1994.12.24	00:01:20	Ардын хөгжмийн цөөхүүлтэй
		“Тоож Нанаа”				
17	Э.Сандагжав (ТЗДБЧ-ын дуучин)	“Мандуул хааны магтаал”	№33250	2000.01.21	00:02:30	Ардын хөгжмийн цөөхүүлтэй
18	А.Бат-Очир (УАДБЧ-ын хөгжимчин)	“Дөрвөн холбоо”	№33251	2000.05.22	00:04:20	Морин хуурын хамсраатай
19	Б.Бат-Орших (“Домог” хамтлагийн ахлагч)	“Хөөмийн холбоо аялгуу”	5766, 395 CD 6-р дуу	2012.03.19-нд медиа архивд	00:04:52	Морин хуурын хамсраатай (“Биширтүгэй айтугай” цомгоос)
20	Б.Амартүвшин (“Домог” хамтлагийн хөөмийч)	“Хөөмийн сэтгэмж”	5767, 395 CD 7-р дуу	2012.03.19-нд медиа архивд	00:03:48	
21	Д.Хосбаяр (“Эгшиглэн” хамтлагийн хөөмийч)	“Хөөмийн уран сэтгэмж”	18414, 667 CD 4-р дуу	2014.03.14-нд медиа архивд	00:05:00	“Эгшиглэн” хамтлаг хөгжимдөнө (“Товь” цомгоос)
22	Б.Батжаргал (“Түмэн Эх” чуулгын дуучин)	“Монгол хөөмийн төрөл”	13473, 527 CD 11-р дуу	2013.05.30-нд медиа архивд	00:03:52	морин хуурын хамсраатай
23	Я.Цогбаатар (“Мандухай” чуулгын хөөмийч)	“Хөөмийн хэлхээ аялгуу” (Ягаанбаатарын найруулгаар)	№33200	бичсэн 1993.02.25, 2013.12.20-медиа архивд	00:02:55	Ардын хөгжмийн цөөхүүлтэй

Харин 1989-2006 онуудад хамтлаг, хоршил, гурвал хэлбэрийн 12 хальсанд 13 бүтээл радиогийн архивд бичигдсэн бол 2013, 2014 онуудад уран бүтээлчдийн цомгоос радиогийн архив руу хуулсан 4 бүтээл байна. Үүнийг дараах хүснэгтэд мэдээлэв.

Хүснэгт 8. Радиогийн фондод байгаа хөөмийн хамтлаг, хоршил, гурвал бүтээлүүд

Д.д	Хөөмийчийн нэр	Хөөмийлсөн бүтээл	Хальс-ны дугаар	Огноо	Хугацаа	Нэмэлт мэдээлэл
1	“Жаргалантын цуурай” хамтлаг	“Есөн эрдэнийн орон”	№32699	1986.12.22	00:04:28	Медиа архивд ороогүй
2		“Гоож Нанаа”	№32700		00:01:05	
3	Д.Цэрэндаваа (Ховд),	“Хөгнө хааны магтаал”	№32886	1987.12.07	00:06:10	Хуучрын хамсраатай (хуучирч О.Болдоо)
4	Ш.Даш (Хөвсгөл)	“Алтайн магтаал”	№32887		00:06:10	
5	Т.Ганболд (УАДБЧ), дуучин Д.Түвшинжаргал, А.Нэргүй	“Дөрвөн настай халиун”	№32762	1987.06.23	00:03:40	Морин хуурын хамсраатай (морин хуурч И.Цогбадрах)
6	Т.Ганболд (УАДБЧ), дуучин Д.Түвшинжаргал	“Хоёр бор”	№32911	1987.12.17	00:03:10	Морин хуурын хамсраатай (морин хуурч Ч.Батсайхан)
7	М.Бямбасүрэн, Л.Базарваань (“Сэлэнгийн долгио” чуулга)	“Алтайн магтаал”	№33045	1989.01.13	00:04:22	Морин хуур, товшуур, төмөр хуурын хамсраатай
8		“Хавьтуулдаггүй л хөөс”	№33075	1989.09.24	00:02:29	Медиа архивд ороогүй
9	М.Бямбасүрэн, Л.Базарваань, Х.Телеухавил (“Сэлэнгийн долгио” чуулга)	“Цэнхэрлэн харагдах уул” “Хонин жороо морь”	№33046	1989.01.13	00:02:37	ёочин, хулсан хуурын хамсраатай (дандилдах)
10	Г.Явгаан, Ш.Даш, О.Болдоо (УАДБЧ)	“Хангай хааны магтаал”	№33108	1990.04.02	00:05:05	Товшуур, морин хуурын хамсраатай
11	Г.Явгаан, Ш.Даш, О.Болдоо, Г.Алимаа, Л.Дэжидмаа (УАДБЧ хамтлаг)	“Богд Дүнжингаравын магтаал”	№32929	1990.04.24	00:03:50	Товшуур, цэн, морин хуурын хамсраатай
12	Д.Гантулга, дуучин Г.Бямбажаргал (“Түмэн эх” чуулга)	“Хартай сарлаг”	№33275	2006.04	00:03:35	Ардын хөгжмийн цөөхүүлтэй

13	Т.Ганболд, хүү Г.Балжинням	“Монгол хөөмийн холбоо аялгуу”	20755, 771 cd 4-р дуу	2014.12.24- нд медиа архивд	00:03:41	Морин хуурын хамсраатай (2005 онд гарсан “Гайхамшигт монгол хөөмий” цомгоос)
14		“Гоож Нанаа”	20760, 771 cd 9-р дуу		00:02:47	
15	Д.Ариунболд, Ж.Батбаяр (хөөмийч)	“Мандухай сэцэн хатан”, “Мөнх тэнгэрийн хүчин дор” МУСК-ны хөөмийн аялгуу	13743, 534 CD, 6-р дуу	2013.06.12- нд медиа архивд	00:05:47	Үндэсний найрал хөгжимтэй (2005 онд гарсан “Best of khoomii” цомог)

Эдгээрээс ажиглахад, хамтлаг болон хоршил, гурвал хэлбэрээр бичүүлсэн бүтээлүүд ихэвчлэн шахаа хөөмийгөөр аялан дуулсан магтаалын төрлийн бүтээл бол, гоцлон хөөмийлсөн бичлэгүүдийн дийлэнх нь исгэрээ хөөмийгөөр ардын болон уртын дууг хөөмийлжээ.

Дээрх ардын дууны 3000 гаруй дуу бүхий хөмрөгөөс гадна “Хөгжим-уран сайхны нэвтрүүлэг”-ийн данс бүртгэлд хөөмийн урлагт хамаарах хэд хэдэн нэвтрүүлгүүд хадгалагдаж байна. Тухайлбал, 1985, 1989 онуудад “Ардын хөгжмийн сан” цуврал нэвтрүүлгээр хөөмийн тухай 2 дугаар бэлтгэгдсэн бол 1983, 1987 онуудад хөөмийн урлагт хамаарах мөн 2 нэвтрүүлэг бэлтгэж сонсогчдын хүртээл болжээ (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Радиогийн фонд дахь хөөмийн урлагийн тухай дагнасан нэвтрүүлгүүд

№	Нэвтрүүлгийн нэр	ХН №	Огноо, хугацаа	Үргэлжлэх хугацаа	Эргэлт	Хувь
1.	“Өгүүлэхийн эрхтэнтэй шүтэлцээт урлаг” нэвтрүүлэг /Ж.Бадраа/	№24	1983.02.04	00:19:43	38	1
2.	“Ардын хөгжмийн сан”: Хөөмийн тухай	№43	1985.01.05	00:17:36	38	1
3.	“Ардын хөгжмийн сан”: Язгуур урлаг мөнх ундраатай	№2	1989.06.18	00:29:00	38	1
4.	“Алтайн хөг эгшиглэн” УГЖ хөөмийч Довчингийн Сундуйн тухай	№298	1997.01.09	00:25:38	19	1

Хэлэлцүүлэг

Энэхүү судалгааны үр дүнд МҮОНР-ийн хөгжмийн архивд хадгалагдаж буй хөөмийн урын сангийн баримтжуулалтын өнөөгийн нөхцөл байдал, түүний ангилал, хадгалалтын онцлогийг дараах байдлаар тодорхойлов.

Радиогийн эргэлтийн сан дахь хөөмийн дуу бичлэгийг он цагийн дарааллаар авч үзвэл, анхных нь 1962 оны 1 дүгээр сард хөөмийч Г.Чимэддоржийн бичлэг хамаарах бол, студид бичигдсэн бичлэгийн сүүлийнх нь 2006 онд “Түмэн эх” чуулгын хөгжимчин, хөөмийч Д.Гантулгын “Хартай сарлаг” (дуучин Г.Бямбажаргалтай хамтарсан) бүтээл бичигджээ. Харин медиа архивд 2012-2014

онд уран бүтээлчдийн гаргасан цомгоос радиогийн архив руу хуулж хадгалсан хөөмийн хэд хэдэн бичлэгүүд байна. Бидний судлан тодруулснаар одоогийн байдлаар радиогийн эргэлтийн санд 73 хадгаламжийн нэгж (хальс) бүхий давхардсан тоогоор 114 хөөмийн бүтээл хадгалагдаж байна. Бичлэгийн агуулгын төрөлжилтийн тухайд студид бичигдсэн бүтээлүүдийн дийлэнх нь монгол ардын дуу, уртын дуу давамгайлсан бол уран бүтээлчдийн цомгоос хуулж медиа архивд хадгалсан цөөн бүтээлүүд бүгд хөөмийн төрөл зүйл, онцлогийг үзүүлсэн зохиомжит, уран сэтгэмжийн бүтээлүүд байна.

Уран бүтээлчдийн гоцлон хөөмийлсөн бичлэгүүдийн дийлэнх нь исгэрээ хөөмийгөөр, цөөн тооны бүтээлүүдэд хархираа, исгэрээ, шахаа хөөмийн дуугаралт, бусад техникийг үзүүлжээ. Харин хамтлагаар болон хоршин хөөмийлсөн бичлэгүүд ихэвчлэн шахаа хөөмийн төрлөөр аялгуулан дуулсан гүйцэтгэл давамгайлжээ (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Радиогийн эргэлтийн сан хөмрөг дэх хөөмийн бичлэгийн нэгтгэл

№	Хөөмийн бичлэгийн хэлбэр	Хадгаламжийн нэгж (хальсны тоо)	Дуу, бүтээлийн тоо	Хамаарах огноо	Бичлэгийн нийт метraj
1	Гоцлол	58	97	1962-2013	03:25:55
2	Хоршил	9	10	1987-2014	00:38:11
3	Гурвал	3	4	1987-1990	00:11:22
4	Хамтлаг	3	3	1986-1990	00:09:23
5	Нийт	73	114	1962-2014	04:24:51

Судалгааны үр дүнд нийт давхардсан тоогоор 114 бүтээлийн бичлэгийг олж нэгтгэсэн бөгөөд эдгээрээс 17 нь хамтлаг болон хоршил, гурвал хэлбэрийнх, бусад нь гоцлон хөөмийлсөн бичлэгүүд юм. Тэдгээр бүтээлийн хөгжмийн хамсрааг ажиглавал, морин хууртай-23, ёочинтой-13, товшууртай-6, хуучиртай-5, ятгатай-4, домбортой-4, гитартай-2, ёочин-ятгын хоршилтой-2, ёочин-хэл хуурын хоршилтой-2, үндэсний хөгжмийн цөөхүүл (найрал)-тэй 16, ямар нэгэн хөгжимдүүрийн хамсраагүй-25, хөгжимдүүрийн хамсраа тодорхойгүй-19 байгааг нэгтгэн мэдээлэв (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Хөөмийн бичлэг дэх хөгжимдүүрийн хамсрааны нэгтгэл

№	Хөөмийн бичлэгийн хэлбэр	ёочин	морин хуур	товшуур	хуучир	ятга	ёочин, ятга	хэл хуур	домбор	гитар	үндэсний хөгжмийн цөөхүүл (найрал)	хамсраагүй	тодорхойгүй
1.	Гоцлол	11	16	3	3	4	2		4	2	13	25	14
2.	Хоршил		4	1	2						3		3
3.	Гурвал		3	2				3					
4.	Хамтлаг												2
	Нийт	11	23	6	5	4	2	3	4	2	16	25	19

Дээрх бичлэгүүдийг радиогийн ямар ямар нэвтрүүлгийн эргэлтэд ашигласан талаар бүртгэл мэдээлэл одоогоор тодорхойгүй байна.

Судалгааны явцад дараах хязгаарлалтууд үүсэж байв. Зарим хальс, бичлэгт мэдээлэл дутуу тэмдэглэгдсэн, эх сурвалж тодорхойгүй, хальс, бичлэгүүд бүрэн гүйцэд медиа архивд шилжээгүй байгаа нь зарим талаар эрж хайсан бичлэгийг сонсож нягтлах боломжууд хязгаарлагдав. Мөн хөгжимдүүрийн хамсрааны бүрэн бус бүртгэл, хамтлаг уран бүтээлчдийн бүрэлдэхүүний нэрс тодорхойгүй байх зэрэг нь судалгааны үр өгөөжид нөлөөлж болохуйц асуудал тул архивын баримтжуулалтыг сайжруулахын тулд юуны түрүүнд аналог хадгаламжийн нэгжүүд (хуучирсан хальс бичлэг)-ийг бүрэн гүйцэд дижитал формат руу шилжүүлэх, системчилсэн каталог үүсгэх шаардлагатай нь ажиглагдав. Угтаа эл судалгааны үр дүн нь хөөмийн урын сангийн орчин үеийн хөгжмийн урлаг дахь хэрэглээ, нийтэд түгээх арга замыг тодорхойлоход чухал ач холбогдолтой бөгөөд монголын язгуур урлагийг шинэ хэлбэрээр хөгжүүлж буй уран бүтээлчид, хөгжмийн продюсер, хөөмийчдөд архивын материалд тулгуурласан уламжлалт урын сангийн суурь мэдээллийг өгөх шинжлэх ухааны болон хэрэглээний ач холбогдолтой.

Цаашид МҮОНР-ийн сан хөмрөг дэх архивын материалуудыг орчин цагийн дижитал платформуудаар дамжуулан зорилтот хэрэглэгчдэд зүй зохистой ашиглуулах, олон нийтэд хүртээмжтэй сонсох боломжийг нэмэгдүүлэх тал дээр бодлого, төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байгаа нь судалгааны явцаас ажиглагдлаа.

Дүгнэлт

МҮОНР-ийн хөгжмийн фонд дахь хөөмийн дуу бичлэгийг судалж, эх сурвалжтай мэдээлэх зорилго бүхий уг судалгааг дараах байдлаар дүгнэж байна.

Нэгдүгээрт, МҮОНР-ийн хөгжмийн архивын сан хөмрөгт судалгаа хийх нөөц боломж зарим талаар хязгаарлагдмал байсан ч бид сан хөмрөг дэх ардын дуу хөгжмийн 3270, хөгжим-уран сайхны нэвтрүүлгийн 106 хальс бүхий эх сурвалжид тулгуурлан хөөмийн уран бүтээлийг шүүн тодруулж, эх баримт болон медиа архивтай тулгалт хийв. Үүний үр дүнд хөөмийн дуу бичлэгүүдийн бүртгэлийн код, огноог баталгаажуулах байдлаар 73 хальсны 114 бүтээлийг бүртгэж, жагсаалтын сан үүсгэв.

Хоёрдугаарт, Радиогийн сан хөмрөгт хадгалагдаж буй дуу бичлэгүүд хэдийгээр хөөмийн урын сангийн баримтжуулалтыг бүрэн тодорхойлох боломжгүй ч тэдгээрт тулгуурлан уламжлалт урын санг тодруулах, хөгжлийн үечлэлийн чиг баримжаа гаргах, сан хөмрөгийн баяжуулалтад нөлөөлсөн хүчин зүйлсийг харж болох боломжууд судалгааны явцаас ажиглагдав. Тухайлбал, МҮОНР-д хадгалагдаж буй хөөмийн урын сангийн дийлэнх нь буюу 50 орчим хувь нь 1980-1990 онд хамаарч байгаа нь тухайн үед улсын хэмжээнд зохион байгуулагдсан уралдаан наадмууд нөлөөлсөн байгаа нь анзаарагдав.

Гуравдугаарт, Радиогийн сан хөмрөгт хадгалагдаж буй дуу бичлэгүүдээс хөөмийн өвлөн уламжлагчид, уран бүтээлчид, уран сайханчдын ур чадвар, гүйцэтгэлийн онцлог, хөгжимдүүрийн хэрэглээ зэргийг он цагийн байдлаар харьцуулж, нарийвчлан судлах боломжууд байгаа нь харагдав.

Цаашид дуу болон дүрс бичлэгийн баримтжуулалтад тулгуурлан хөөмийн урлагийн салбарт дижитал хадгалалтын стандартыг боловсронгуй болгох, медиа архивын нэгдсэн сан бүрдүүлэх, түүнийг судалгаа, уран бүтээлийн эргэлтэд оруулах, олон улсад сурталчлах үүднээс баримт, эх сурвалжтай ашиглуулах, түгээх талын суурь, хавсарга судалгааг хэрэгжүүлэх боломжууд хүлээгдэж байна.

Талархал: Тус судалгааг гүйцэтгэх нөхцөл боломжоор хангасан СУИС-ийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн захиргаа, МҮОНР-ийн Хөгжмийн фондын эрхлэгч, Утга зохиол соёл, урлагийн албаны ажилтан, албан хаагчдад гүн талархал илэрхийлье.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

МҮОНР-ийн “Ардын дуу”-ны бүртгэлийн жагсаалт, I боть. Хөгжмийн фондын эргэлтийн сан хөмрөг.

МҮОНР-ийн “Ардын дуу”-ны бүртгэлийн жагсаалт, II боть. Хөгжмийн фондын эргэлтийн сан хөмрөг.

МҮОНР-ийн “Хөгжим-уран сайхны нэвтрүүлэг”-ийн бүртгэлийн жагсаалт. Хөгжмийн фондын эргэлтийн сан хөмрөг.

Сандагжав, Э. 2009. *Монгол хөөмийн урлаг*. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Цэдэн-Иш, А. 2009. *Хөгжим*. Улаанбаатар: Жиком пресс.

Англи хэлээр:

Amarjargal, M. 2025. “Development of Mongolian *khöömii* traditional art: From Ritual to Repertory.” *The 17th Annual Mongolian Studies Conference*: 234-243. February 14-15, Washington D.C.

Curtet, Johanni. 2013. “The transmission of *höömij*, an art of vocal timbre: ethnomusicology and history of Mongolian overtone singing.” Ph.D diss. University of Rennes 2.